БАТЛАВ: МАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ ..... (Э.БАЯРХҮҮ)

МАНДАЛ СУМЫН 1, 4-Р БАГТ БЭЛЧЭЭРИЙН
ХУДАГ БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 01 сарын 13 өдөр Дугаар №01 Сэлэнгэ, Мандал сум

1	Үндэслэл	Мандал Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
2	Төслийн зорилго, ач холбогдол	Ундны усаар хангах
3	Захиалагч байгууллага	Сэлэнгэ аймгийн Мандал сумын Засаг даргын тамгын газар
4	Санхүүжилтийн эх үүсвэр	Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө
5	Байршил, хамрах хүрээ	• Мандал сумын 1, 4-р баг
6	Ажлын иж бүрдэл, үе шат	1. Цооногийг өрөмдөх, тоноглох • Цооног ашиглалтын ундарга 2л/сек ба түүнээс дээш • Худгийг өрөмдөх гүнийг судалгаан дээр үндэслэн тогтоох • Цооногийн гүнийг геофизикийн судалгааны үр дүнгээр тогтооно • Суултын яндангийн материал ган хоолой эсвэл зөвшөөрөгдсөн хуванцар хоолой, ф159 мм-ээс багагүй • Шүүрийн яндангийн материал ган хоолой эсвэл зөвшөөрөгдсөн хуванцар хоолой, ф159 мм-ээс багагүй, 1м-т 500ш-ээс багагүй ф18-20 мм цоолбор шүүртэй • Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэмжээтэй, 10-15 мм –ээс томгүй байх • Тунгаагуурын урт 2м • Худгийн өрөмдлөгийн ажлын талаар болон өрөмдлөгийн ажил дуссаны дараах угаалт, цэвэрлэгээний ажлыг ажлын журналд тэмдэглэх • Шавхалт хийх хугацаа 72 цагаас доошгүй байна. • 32мм диаметртэй, хайрцагнаас 2м урттай гадагшилсан ган хоолойг гаргах 2. 5м-ээс багагүй урттай, 40 см-ээс багагүй голчтой ган төмөр хоолойгоор онгоц хийнэ, онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана, нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ /кранттай/, онгоцны ирмэгийг аюулгүй болгож засна. 3. Онгоцны нийт уртын дагуу 2 талдаа тус бүр 1,5 м өргөнтэй 10 см зузаан 150 маркаас доошгүй бетон хийцтэй талбай байна. Талбай нь бага зэрэг налуу, ус тогтохоргүй хийгдэнэ. 4. Нарны хавтан (2000w-2500w), Нарны байрлалд шилжих эргэдэг хөл, гүний худгийн насос (1000-1500w), нарны инвертор (solar controller) 5. Хамгаалалтын торон хашаа-16м урттай, 1м өндөртэй
7	Гүйцэтгэх ажилд тавигдах ерөнхий	Усны тухай хууль болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм

	шаардлага	бусад холбогдох стандартад ("Худгийн цооног өрөмдөх, суурилуулахад тавигдах техникийн шаардлага" MNS6088-2010) нийлүүлэн сүүлийн үеийн дэвшилтэт технологи ашиглан ажлын даалгаврын дагуу чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.
8	Гүйцэтгэгч байгууллагад тавигдах шаардлага	Холбогдох тусгай зөвшөөрөлтэй байх
9	Ажил гүйцэтгэх	Гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ.
10	Зөвшилцөх, батлуулах байгууллага	Холбогдох байгууллага: • БОАЖЯ • Сэлэнгэ аймгийн Мандал сумын ЗДТГазар • Сэлэнгэ аймгийн Мандал сумын Онцгой байдлын газар • Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар • Бусад холбогдох орон нутгийн байгууллагууд
11	Геофизик	Хайгуул судалгаа хийж танилцуулах
12	Байгаль орчин, үнэлгээ	Хүрээлэн буй орчин, хөгжлийн ирээдүйг бодолцсон цаашдын ашиглалтын үеийн эдийн засгийн үр ашигтай шийднэ, шаардлагатай нөхцөлд үнэлгээг тухай бүрт нь хийлгэнэ.
15	Ажлын үр дүнг хүлээлгэн өгөх	Ундны усны стандартад нийцсэн эсэх итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ, дүгнэлт БОАЖЯ-ын зөвшөөрөл Худгийн паспорт Нарны үүсгэвэр болон насосны ашиглалтын болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа Гэрчилгээ

Боловсруулсан: О.Энхболд (Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)